



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУГАТ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХУРААНГУЙ АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/015/НА-СА-ТТЗ

Цахим
хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.4.1 Мөнгөн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.2 Авлага	Error! Bookmark not defined.
3.5.3 Урьдчилгаа	Error! Bookmark not defined.
3.5.4 Бараа материал	Error! Bookmark not defined.
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.6 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.7 Өр төлбөр	Error! Bookmark not defined.
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	Error! Bookmark not defined.
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	6
5.3 Зөвлөмж.....	6
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.03.25 № 346
танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.УУГАНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бугат сумын Төсвийн төлөвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Сумын ИТХ-ын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай V/02 дугаар тогтоолоор татварын болон татварын бус нийт 669.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 694.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 103.4 хувиар биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг

6326050576

нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бугат сумын Засаг дарга 2025 онд 7 хөтөлбөрийн хүрээнд 2,312.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 2,007.6 сая төгрөгийг зарцуулж 305.1 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Сумын ИТХ-ын 2025 оны VI/02 дугаар тогтоолоор сумын Засаг даргын үйл ажиллагааны “Бугатын сэргэлт” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 85.4 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 122.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөрчилд¹ 9.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, өмнөх оны аудитын шийдвэрийг биелээгүй зөрчилд холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх 1 албан шаардлага, 22.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 1,329.9 сая төгрөгийн зөрчилд² илэрснээс, 4.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 17.4 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 54.8 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн байна.

2.1 Албан шаардлага

1.Өмнөх оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Орон нутгийн сангийн тайланд 20.0 сая төгрөгийн 3 зөвлөмж, Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд 1.17 сая төгрөгийн 2 зөвлөмж, Сумын нэгтгэсэн тайланд 57.1 сая төгрөгийн 1 зөвлөмж, 20.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 7.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт хүргүүлсэн ч одоог хүртэл биелүүлээгүй fas.sistem-д биелэлтийн тайлагнаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

2. Байгаль хамгаалах сангаас түймэр унтраах хүмүүсийн хүнс бэлтгэсэн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данс:

Илрүүлэлт:

Ерөнхий орлогын тайланд өмнөх оны хувь хүнээс авах авлага 2.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

2. Нийт зардал:

Илрүүлэлт:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд нийт 12.6 сая төгрөгийг зарцуулаагүй /ан амьтан, байгалийн ургамал/ нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хуульд заасны дагуу тухайн байгалийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, зарцуулах.

3. Өглөгийн данс:

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлын дутуу 7.8 сая төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тогтмол зардлыг холбогдох хуульд заасны дагуу төлөвлөж, санхүүжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	2	9.9	2	9.9			2	9.9				
ОНХС	1	204.49			1	204.49	1	204.49				
Дүн	3	214.39	2	9.9	1	204.49	3	214.39				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	99.7			1	2.4	1	9.9	1	87.4		
ЗДТГ	8	30.05	4	3.07	2	15.08	1	6.4	1	5.5		
Соёлын төв	2	4.81					2	4.81				
Дүн	13	134.56	4	3.07	3	17.48	4	21.11	2	92.9	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
ОНХС	1	873.56					1	873.56		
ХХС	1	24.69					0	0	1	24.69
Дүн	2	898.25					1	873.56	1	24.69
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
ТТЗ	1	12.6							1	12.60
ЗДТГ	2	19.9			1	1.0			1	18.90
ОНХС	1	0							1	
ХХС	2	0							2	
Нийт дүн	6	32.5			1	1.0			5	31.5